

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№20/524

ШУС, НУС

2019

НАМЫН БАЙГУУЛЛАГЫН ХЯНАЛТ, ӨӨРСДИЙН ШҮҮМЖЛЭЛ ХҮЧТЭЙ БАЙЖЭЭ

*(Хэд хэдэн удаа донгодуулж, нэг удаа шатаалгасан Хөвсгөл аймгийн “Эрх чөлөө”
сонины жишээн дээр)*

Д.Батжаргал*

*МУИС-ийн Утга зохиол, урлаг судлалын тэнхимийн багш, доктор (Ph.D)

Түлхүүр үг: Нэг намын тогтолцооны үеийн сэтгүүл зүй, хяналт, цензур, түүний үр нөлөө, өөрсдийн шүүмжлэл, үр дүн, орон нутгийн сонины хөгжил

Энэхүү өгүүлэлд орон нутгийн нэгэн сонины 70 гаруй жилийн түүхийг он дарааллаар товчоолон өгүүлэхийг эрмэлзсэнгүй, зөвхөн намын хяналт, цензур ямар байв, өөрсдөө бүтээлдээ хэрхэн шүүмжлэлтэй ханддаг байсныг тодруулахыг зорилоо. Орон нутгийн сонин үүсч эхэлсэн дөчөөд онд анхны дугаараа гаргаж эдүгээ хүртэл нэрээ солиогүй, ард олондоо “оюуны талх” түгээх үүргээ ямар нэг хэмжээгээр биелүүлсээр иржээ. Энэ тухай сэтгүүл зүйн түүхийн баримт сөхье.

МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчоо 1944 оны 11 дүгээр сарын 6-нд тогтоол гаргаж, Хөвсгөл аймагт “Эрх чөлөө” сонин гаргахаар шийдвэрлэжээ. Ингээд анхны дугаар нь 1945 оны нэгдүгээр сарын 1-нд хагас хэвлэлийн хуудсаар 300 хувь хэвлэгджээ. Тэр үед гараар эргүүлж хэвлэдэг ганц машин, босоо монгол үсгийн хоёр касс /үсгийн сан/, 17 ажиллагсадтай байсан бөгөөд сонины анхны эрхлэгч нь Ж.Сахъяа байв.

“Эрх чөлөө” сонины тулгын чулууг тулж, гал голомтыг нь бадраасан Ж.Сахъяа, Ж.Галсандорж, Ч.Янсан, Г.Төмөрбаатар, Т.Дулмаа, С.Чойсүрэн, Баасанжав нарыг анхны долоо хэмээн ярилцдаг аж.

Анхны дугаарын эхний нүүрэнд МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны 1944 оны 11 дүгээр сарын 6-ны өдрийн 72 дугаар хурлаас аймгуудад шинээр байгуулах сонины үүргийн тухай тогтоолыг бүрэн эхээр нь нийтэлжээ. Уг тогтоолд 1945 оны эхнээс уул сониныг долоо хоногт 2 удаа, тус бүр мягмар, баасан гарагт гаргаж байсугай гэж тэмдэглэжээ.

Мөн дугаарт мал өсгөсөн мэдээнээс гадна болсон явдлыг үнэнээр нь өгүүлсэн “Улсын ударникийн яриа”, “Энэ хашааг”, “Тэмцээн болов” гэх мэтийн материал орсны дээр аймгийн бэлтгэлийн комиссын дансанд орж буй нийтийн бэлтгэлийн мөнгө 1944 оны 12 дугаар сарын 30-ны байдлаар гаргасан сонин тоо баримтыг Бүрэн сум 31 мянга, 4 зуун 38 төгрөг, 44 мөнгө, Тосонцэнгэл 10 мянга 2 зуун 13 төгрөг 29 мөнгө оруулсан... гэх мэтээр сум сумаар нь жагсааж бичсэн байна.

Анхны дугаараасаа ардын дунд орж, аймгийн боловсрол, соёлыг

хөгжүүлэхийн төлөө анхаарал тавьж цаг үеийн шинэ сонин мэдээ нийтэлж байсан байна. Мөн шүүмжлэлт материал оруулж байжээ. Баянзүрх суманд сонин уншлага таслах явдал их байгааг шүүмжилж “Сонин уншлага таслагчид” гэсэн мэдээнд “12-р сарын нэгнээс 19-нийг хүртэлх сонин уншлагад Эвлэлийн үүрийн дарга Ранжин 12 удаа, хошууны галч Аюуш 6 удаа тасалсан” хэмээн нэр усаар нь бичсэн байх юм. “Эрх чөлөө” сонины анхны дугаарууд хэвлэгдэн гарч байх үед дэлхийн II дайн дуусаагүй байсан учраас Зөвлөлтийн улаан армийн ялгуусан давшилт болон улаан армид монголын ард түмнээс тусалж байсан тусламжийг дэлгэрэнгүй мэдээлж байжээ.

1946 оноос “Эрх чөлөө” сонин кирилл үсгээр гарч эхэлсэн байна. Энэ үед сонины эрхлэгч Ж.Сахъяа “Хариуцлагагүй тэргүүлэгч” гэсэн шүүмжлэлт мэдээнд “*Бүрэн сумын намын үүрийн суртлын хэрэг эрхэлсэн тэргүүлэгч бөгөөд сумын нарийн бичгийн дарга Ц.Цэяан намын үүрийн дарга нарын сарын түр курсын үеэр намын үүрийн даргыг орлож байлаа. Гэтэл энэ завсар аймгийн “Эрх чөлөө” сонин хяналтын ёсоор багуудад очих “Эрх чөлөө” сонины 1 дүгээрээс 8 дугаарыг хүртэл 47 ширхгийг 2 дугаар сарын 12-ны өдөр хүртэл тэргүүлэгч Цэяан остольдоо /стол /ширээ/ гэсэн орос үгийг ингэж бичжээ. Д.Б/ хадгалж байжээ. Энэ сонин захиалсан хүмүүсдээ очсон бол их л хэрэгтэй байх ёстой юм. Аймгийн “Эрх чөлөө” сонин бол аймаг сум баг аж ахуйтны ажиллагаа тэдний сайн туршлагыг солилцуулах, тэрчлэн одоо үед чухал юу шаардагдаж байна. Түүнийг яаж хийх тухай чухал зүйлийг бичдэг, намын бие ухуулагч нь юм. Энэ учраас ч малчин, ажилтан, ажилчид өргөнөөр захиалан*

уншдаг байна. Ийм үүрэгтэй хэвлэлийг дарагдуулан саатуулж байсан нь даанч хортой байна. Тэргүүлэгч Цэяанд багуудын захиалсан сониныг зохих хүмүүст нь хүргүүлэх бүрэн бололцоо байлаа...” гэх¹ зэргээр хурц шүүмжлэн бичжээ. Ингэж сониныхоо түгээлт, тараалт хүргэлтэд анхаарал тавьж хариуцлагагүй гоомой намын ажилтныг хайр найргүй зэмлэн сониндоо нийтэлж байв. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл өөрийн бүтээгдэхүүний хүргэлт, борлуулалтад хяналт тавих хэрэгтэй. Захиалагчид хугацаандаа очих ёстой сонин замдаа хэн нэгний ширээ, шүүгээнд хадгалагдаад байвал юу болох вэ. Иймээс өөрийн хяналт шүүмжлэлээ зөв тавьж байжээ.

“Эрх чөлөө” сонин 1945 онд 300-2100 хувь гарч байсан бол 1946 онд 2700 болон өсөж, олон түмний итгэлтэй, хүндтэй индэр болсон. МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчоо 1946 оны 10 дугаар сарын 17-нд Хөвсгөл аймгийн “Эрх чөлөө” сонины тухай хэлэлцэж тус сонины ажилд үнэлэлт, дүгнэлт удирдамж өгчээ. МАХН-ын Төв Хорооны тогтоолд тэмдэглэхдээ “Сонинд бичсэн материал нь Хөвсгөл аймгийн хөдөлмөрчдийн дунд нам, засгийн бодлогыг зөвөөр тайлбарлаж, амжилттай биелүүлэн, тэднийг идэвхжүүлэхэд чиглэгджээ. Тус аймгийн нам, захиргаа, аж ахуйн байгууллагын ажлын дутагдлыг зоригтойгоор илрүүлж, зарим цалгар назгай ажилтныг шүүмжлэн үүгээрээ дутагдлыг түргэн засуулахад нь уг байгууллагуудад тусалж, ажлын дутагдалтай шийдвэртэй тэмцэхэд олон түмнийг дайчилж байна. Энэ ч учраас “Эрх чөлөө” сонин ард түмний дунд нэр хүндтэй байна” гэжээ. “Эрх чөлөө” сониныг “нялх балчир” байхад нь үнэлсэн үнэлэлт энэ.

Тэр цагаас хойш “Эрх чөлөө” сонин аймгийнхаа ард түмний нүд, чих, чөлөөт индэр болсоор өнөөг хүрчээ. Дөчөөд оны “Эрх чөлөө” ноос, ноолуур “Алтан фонд”, “Бүхнийг фронтод”, “Шинэ үсэгт ард нийтээр суралцъя” гэсэн уриа хэрэгжүүлэхэд хуудсаа өргөн дэлгэж бас ёс суртахууны асуудлууд хөндөн нийтэлж байв. Тус сонины 1951 оны 64 дүгээрт гарсан нэгэн мэдээг бүрэн эхээр нь нийтэлъе.

ҮНЭЭГЭЭ НИЙЛҮҮЛЭГТ БҮРЭН ОРУУЛЖ БАЙНА

Баянзүрх сумын 8 дугаар багийн ард Шагдарын Осор 1950 онд 10 үнээгээ нийлүүлэгт оруулж чадсан учраас үнээ нэг бүр нь одоо цөм тугалтай байна. 1951 онд нөхөр Осор үхэр дотроо орж, 20 минут ажиглан харж үнээний дур урамшил орж байгаа байдлыг шинжиж байгаад хээлтүүлэгч малтай нийлүүлж, нийлүүлгийг зохиодог туршлагатай малч хүн юм. Ийм нягт нямбай ажилладгаас нэг ч хээлтэгч малыг сувайруулдаггүйн гадна нөхөр Осор 1950-1951 онд үхэр өсгөх төлөвлөгөөг олон толгойгоор давуулан биелүүлж, намын гишүүний манлайлах ролыг хангаж, 1950 оны нэгдүгээр сард хуралдсан Намын Төв Хорооны бүгд хурлаас үхэр сүргийг өсгөх талаар тавьсан чухал зорилгуудыг хангаж байна.

Иймд манай намын гишүүд, үхэр сүргийг нийлүүлэгт хүчтэй оруулж бүрэн хээл авахуулах явдалд хөдөлмөрчин олныг ингэж хошуучлах нь чухал байна. Баттогтох.

Намын байгууллагын хяналт хүчтэй алдаа оноог хурц шүүмжлэн хэлэлцдэг, донгодож арга хэмжээ авдаг байжээ. Хэвлэлийн автомат машин төдий л нэвтрээгүй гараар эргүүлж хэвлэдэг машинтай байх үед өчүүхэн жижиг цэг тэмдгийг ч

анхааран ярилцдаг байв. 1950-иад онд хэвлэгчээр ажиллаж байсан Базарын Жигжидсүрэнгийн дурсамжид *“Би Бум-цэнд даргын нас барсан гашуудлын сонин хэвлэж байгаад хацар дээр мэнгэ шиг толбо гаргаж намын хороонд дуудагдаж билээ”* хэмээн² өгүүлсэн байна.

“Эрх чөлөө” сонин анхнаасаа идэвхтэн бичигчдээ гүнээ хүндэтгэн тэдний ирүүлсэн цаг үеийн чухал мэдээг нь нийтэлж, бичигчид нь ч үнэн зөв сайн мэдээлэл илгээхийн төлөө анхаарал тавьдаг, тэр ч бүү хэл нам, төр засагтаа ажлын сайхан амжилтыг илтгэдэг байжээ.

Баянзүрх сумын уугуул Д.Цэдэнсодном гэдэг сонины идэвхтэн бичигч ажлынхаа амжилтыг тэр үеийн нам төрийн тэргүүнд рапорталжээ. Энэ тухай сэтгүүлч Б.Бат-Эрдэнийн бичсэнийг эш татъя.

“Хөвсгөл аймгийн Их-уул суман дахь МААМ /мал аж ахуйн машинт/ станцын бүтээлч хамт олны ажиллагааны үрээр дөрвөн нэгдэлд 300 тонн өвс хадах төлөвлөгөөг 9 дүгээр сарын 10-нд 100 хувь, 235 га-гаас малын ногоон тэжээл, 230 га-гаас эрдэнэ шишийг 8 дугаар сарын 20-ны дотор хадаж даршилснаас гадна 7419 га талбайн үр тариа хураахдаа 8 дугаар сарын 12-ноос 9 дүгээр сарын 26 хүртэл цаг агаарын саатлыг хасаад ангилан хадалтын ажлыг 14 хоногт, цайруулалтыг ажлын хорь хоногт хийж дуусгалаа. Их-Уулын МААМС-ын дарга Чимэддорж, Намын үүрийн нарийн бичгийн дарга Цэдэнсодном” хэмээн МАХН-ын Төв Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга Ю.Цэдэнбалд рапортлахад, нөхөр Ю.Цэдэнбал “Үйлчилж байгаа нэгдлүүддээ өвс хадах төлөвлөгөөг 100

хувь биелүүлж, 7419 га талбайн үр тариаг ажлын 14 хоногт ангилан хадаж, цайруулалтыг ажлын хорь хоногт дуусгаж, га тутмаас 10-14 центнер үр тариа, 25-30 тонн ногоон тэжээл, 100-125 центнер эрдэнэ шиш хураан авч хөдөлмөрийн сайхан амжилт гаргаж байгаа танай станцын хамт олон болон үйлчилгээний хүрээнд байгаа нэгдлийн гишүүд, нам, улс, олон нийтийн байгууллагад МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн өмнөөс халуун баяр хүргэе!” Улаанбаатар хот. 1964.10.05” гэсэн хариу талархал илгээснийг намын “Үнэн” сонинд нийтэлж байжээ” гэсэн³ байдаг.

Ийнхүү төр засаг нь хэвлэлийн үгийг “сонсдог”, бодол санаагаа хуваалцдаг байжээ.

Тус аймгийн сонин 1963, 1967, 1971, 1974, 1977, 1980, 1983, 1987, 1994 онд идэвхтэн сурвалжлагчдын зөвлөгөөнийг нийт есөн удаа хийсэн байна. Идэвхтэн бичигчидтэйгээ нягт холбоотой ажиллаж байсныг олон баримт харуулж байна. Тэдний

нийтлээгүй захидалд утсаар буюу сонины хуудсаар эсвэл захидлаар хариу өгдөг уламжлал ерээд он хүртэл үргэлжилжээ. Дээрээс заавар удирдамж их ирдэг байв. 1944 онд “Үнэн”

сонины газраас “Ард нийтээр өөрийн хэвлэлд оролцъё” гэсэн гарчиг-тай есөн заалт бүхий сануулгад “Сонинд бичих хүн хэзээд үнэн юм бичиж бай. Сонинд бичих хүн өөрийн хувийн өс хонзон, талархал зэргийг огт мартаж, ганцхан болж байгаа хэргийг намын нүдээр үзэж, гагцхүү олон нийтэд тус дэм болох эрхэм зорилгын үүднээс бичих хэрэгтэй” гэж⁴ бичжээ. Энд “намын нүд” гэдэг нь үзэл бодлын том агуулга хадгалж байгаа нь хэнд ч гэсэн тодорхой байна.

Сонины хэвлэх үйлдвэр редакц-тайгаа нэг удирдлагатай учир материаллаг баазаа бэхжүүлэх хотын хэвлэлийн үйлдвэртэй алхаа нийлүүлэн

ажиллахын тулд олон жил эрхлэгчээр ажилласан

Г.Шагдар,
Д.Жүгдэрхүү

нарын хичээл зүтгэл их байв. 1957 онд сонины

хариуцлагатай эрхлэгчээр

томилогдон ирсэн Г.Шагдар

үйлдвэрийн барилга, хэвлэлийн

линотип машин, цайр зурагтай

болгохын төлөө олон даргын

хаалга үүд сахиж, овсгоо самбаа,

санаачилга зүтгэл гарган үр дүнд

хүрсэн байна. Тэрбээр өөрийн

дурсамждаа “Сониноо зурагтай болгох нь чухал байлаа. Энэ талаар нэлээд ярилцаж бодсон ч арга зам тун мухардмал байлаа. Харин зөвхөн надад нэг аятай боломж байж магадгүй санааг-



Дээрээс заавар удирдамж их ирдэг байв. 1944 онд “Үнэн” сонины газраас

“Ард нийтээр өөрийн хэвлэлд оролцъё” гэсэн гарчиг-тай есөн заалт бүхий сануулгад “Сонинд бичих хүн хэзээд үнэн юм бичиж бай. Сонинд бичих хүн өөрийн хувийн өс хонзон, талархал зэргийг огт мартаж, ганцхан болж байгаа хэргийг намын нүдээр үзэж, гагцхүү олон нийтэд тус дэм болох эрхэм зорилгын үүднээс бичих хэрэгтэй” гэж⁴ бичжээ. Энд “намын нүд” гэдэг нь үзэл бодлын том агуулга хадгалж байгаа нь хэнд ч гэсэн тодорхой байна



дав. Энэ нь миний дүү Г.Намсрайжав хэвлэх үйлдвэрийн цайр зургийн мастер, шинийг санаачлагч, нэрд гарч байсан хүн. (Ленинградын хэвлэх үйлдвэрт дадлага хийж байхдаа шинэ бүтээл гаргаж, медалиар шагнагдаж байсан) Техник сэтгэлгээгээр тун сайн төрөлхийн авьяастай хүн байлаа.

Би нэг өдөр дүүдээ сониноо зурагтай болгож өг, намайг л боддог юм бол ухаанаа сийлж үз гэж шууд тулгав. Цайр зураг аймагт ямар ч бололцоогүй гэдгийг хэн хэн нь мэдэж байсан. Иймд шинэ санаачилга хэрэгтэй. Дүү маань анхандаа боломж байхгүй гэснээ за яахав бодож үзье гэв. Тэгээд жил гаруйн дараа нэг арга оллоо. Тачинь миний толгойг ёстой гашилгалаа даа, би очиж хийж өгнө гэв. Цайр зурагт хүн сургахад гарын дүйтэй, техник сэтгэлгээтэй хүн хэрэгтэй байсан учир хэвлэгчээр ажиллаж байсан Г.Аюурсүрэнг томилж дагалдан ажиллууллаа. Хэд хоногийн дараа сонин зурагтай гарч эхлэв. Г.Намсрайжавын сэдсэн ажил шинэ санаачилгад бүртгээгдэж, бүх аймгийн сонинь тийм зурагтай болгох шийдвэр гарч хэрэгжив. Дараа нь дүү маань “хэрэв таныг тэгэж шулуун шууд тулгаагүй бол би зүүдлэх ч үгүй байсан” гэж хэлж байсан юм” хэмээн⁵ бичсэн байна. Боломжгүйгээс боломж бий болж, арга чарга хайж явж аймгийн сониноо “айлын дайтай айл” болгосон хүмүүсийн нэг нь Г.Шагдар. Ингэж 1962 оноос цайр зурагтай, 1963 оноос үсэг өрөх линотип машинтай болсноор үйлдвэрийн хүрээ өргөжиж, хамт олон ч баяр хөөртэй, сэтгэл өөдрөг “Социалист хөдөлмөрийн бригад” болсон байна. Сонины эрхлэгч Г.Шагдар “Эрх чөлөө” сониноо тохилог сайхан байр, цайр зураг, линотип машинтай болгон баярлаж хөөрч явах үед нь 1963 оны “Үнэн”

сонинд нутгархаг үзэлтэн болгон “Аль нутгийнх вэ?” гэсэн шүүмж гарч байжээ. Гэвч гудайсангүй...

Тус хамт олон 1972, 1973, 1975, 1977 онд улсын хэмжээнд шалгаруулсан “Сайхан ном” уралдаанд хэвлэх үйлдвэр, 1980, 1982, 1984 онд “Сайхан сонин”-ы улсын уралдаанд редакц тэргүүн байранд шалгарч байв. Энэхүү амжилт өөрсдийн зарчимч шүүмжлэл, дотоод хяналт шалгалт хүчтэй байсантай холбоотой юм. Сонины загвар хийц нь агаар, бичвэр, зураг чимэглэл гэсэн үндсэн гурван хэсгээс бүрддэг. Хийц муу болхи байгаа талаар дугаарын дараах хэлэлцүүлэг /шуурхай зөвлөлгөөн/-т хурц шүүмжлэн ярилцдаг байсныг сонинд 23 жил ажилласан сэтгүүлч Р.Сандагжав ийнхүү дурсч байна.

“Сонины энэ дугаар /1960 оны/ холбооны газар 40 минут хожимдож хүргээгдсэнээс болж хуваарилж амжилгүй шуудангаас хоцорч хэд хэдэн сум өдрийн дугаарыг бүтэн 3 хоногийн сүүлд хүлээж авлаа гэж манайд гомдол мэдүүлэн Намын хороонд мэдэгдсэн байна. Саатуулсан учир шалтгаан, холбогдох эзнийг нарийвчлан тодруулж өнөөдөр Намын хороонд мэдэгдэх хэрэгтэй... гэхчилэн ярьцгааж байснаа нэг үсэг солигдож «мал» гэхийг «шал» гэж хэвлэгдсэн тухай том яриа болов. Үзсэн чинь «шал өсгөх төлөвлөгөө» гээд хэвлэчихсэн харагдлаа. Алдааны эзнийг олохоор сонинь тэр дугаарын хувийн хэрэг болох хуйлаастай том бичиг задалж үндсэн эхээс нь авахуулаад боловсруулсан утга зохиолын ажилтан, машиндсан бичээч, тулган уншилт хийсэн хүн, өрөлтөд шилжүүлэхийг зөвшөөрсөн нарийн бичгийн дарга, эрхлэгч, түүнийг өрсөн үсэг өрөгч, хянагч, анхны даралт болон сигнал

уншигч цөм гарын үсгээ зурсан том жижиг, урт богино янз янзын хуудас гарлаа. Буруудахын эхлэл үсэг өрөгчөөс үүджээ. Үсэг өрөгч, хянагч хоёр дуудагдав. Буруутан нь тэд юм шиг санагдсан чинь тийм биш болов. Хариуцлагатай эрхлэгчийн даргалсан шуурхай зөвлөгөөний шийдвэр гарлаа. Эцсийн засварт хайнга хандаж хариуцлага алдсан жижүүрийн редактор үйлийн эзэн болж, түүний буруугаас гэж нэр хаягаар нь бичин уншигчдаас уучлал гуйсан залруулгыг дараагийн сонинд гаргахаар тогтов. Тэгээд ч зогссонгүй алдаа гаргасан сурвалжлагчийн тухайн сарын бичлэгийн шагналыг хасах болов”⁶.

Энэ мэт зарчимч хатуу шаардлага бие биедээ тавьдаг болохоор тэр нь үр дүнгээ өгч 1971 онд аймаг байгуулагдсаны 40 жилийн ойгоор социалист уралдаанд шалгарч үүрд хадгалагдах туг хүлээн авч, 1978 оноос хэвлэлийн автомат машинтай болон материаллаг бааз сайжирч, 1983 онд хэвлэл, мэдээллийн байгууллагуудын дунд зарласан “Арвилан хэмнэлтийн аян”-ы болзол хангаж МСХ-ны шагнал хүртжээ.

Цензур хатуу, түүнээс гажсан хүн талхнаасаа салж, гаргасан сонин нь хүчингүй болдог байсан. Иймээс сонин хариуцлагатай эрхлэгч нь айж эмээх нь туулай мэт байлаа хэмээн дурсан ярих хүн элбэг. Гэвч хийе гэснээ хийдэг, хэлье гэснээ хэлчихдэг хүн бас байлаа. Тэдний нэг нь Д.Жүгдэрхүү. 1987 онд сонинд «Нутгийнхандаа хандсан сэтгэлийн үг» тэргүүн бичсэний төлөө эрхлэгч Д.Жүгдэрхүүг нутгархаг үзэл гаргасан хэмээн аймгийн намын хорооны товчооны хурлаас хатуу донгодсон байдаг юм. Угтаа тухайн тэргүүн өгүүлэл нь Бүрэнтогтох суманд ашиглаж болох нөөц боломж арвин их

байгааг сануулсан, шинэ санаа дэвшүүлсэн редакцын байр суурь илэрхийлсэн байхад тэгэж сүржигнэсэн нь инээдтэй хэрэг. Тэр өгүүлэлтэй цуг Хатгал хотын дарга байсан Дэмчигт Намын хорооны товчоогоор арга хэмжээ авсан тогтоолыг нийтэлсэн учир эмзэглэн “Гадны хүмүүс бидний эсрэг нутгийнхнаа хандуулах гэж байна» хэмээн хардсан хэрэг байсан. Асуудал хөндсөн өгүүлэл бичдэг, редакцын бие даасан байдлыг чухалд үздэг, эрдэмтэн зохиолч Ш.Гаадамба /эсэргүү шог шүлэг бичдэг хэмээн ад үзэгддэг Д.Б/, шүүмжлэгч Ч.Билигсайхан нарыг Мөрөнд очих үеэр чөлөөт уулзалт ярилцлага өрнүүлдэг учир Аймгийн намын хороо сэтгүүлч, зохиолч Д.Жүгдэрхүү эрхлэгчид тийм ч таатай ханддаггүй байлаа. Мөн сонинхоо материаллаг баазыг бэхжүүлэн, туслах аж ахуйтай болгосон, аймагтаа тэргүүний байгууллага, улсдаа ч “Эрх чөлөө” сонин дээгүүр давхидаг эхний гуравт лавтайяа багтдаг байсан учир атаархдаг хүмүүс ч их байсан биз. Тиймээс далим болгон шүүмжилсэн хэрэг.

Ийнхүү “эрх чөлөөгүй” эрх чөлөө байх социализмын он жилүүдийн төгсгөл ойртон өөрчлөн байгуулалтын салхи сэвэлзэж асан тэр жилүүдэд “Эрх чөлөө” сонин Монголын сэтгүүл зүйн түүхийн бас нэгэн сонин гэрч болсон юм. “Сонин шатаасан” хэмээн ам дамжин яригдсан тэр түүхийг тус сонинны газар нягтлан бодогч, санхүү, албаны даргаар ажиллаж байсан Ч.Бямбадорж /эдүгээ МоАХ-ны удирдах зөвлөлийн гишүүн/ саяхан дэлгэв.

Наяад оны сүүлээр Хөвсгөл аймгийн “Эрх чөлөө” сонинд нэрт шог зураач, яруу найрагч Г.Нямдорж “Тусгай дэлгүүр”, “Мөрөнгийн цагаан хаалга” /хоёр шүлгийг хавсаргав/ гэдэг хоёр шүлгээ сонинд өгч хэвлэлтээс гарч

тараахаар сум байгууллагуудад нь хуваарилаад байтал гэнэт хэрэг мандаж, аймгийн МАХН-ын хорооноос сонины тухайн дугаар хариуцан хянах ёстой нөхөр нөгөө хоёр шүлгийг олж хараад “Үзэл сурталд нийцэхгүй, дарга удирдлагуудын эрхэнд халдсан, нийгмийн эсрэг чиглэсэн хандлагатай гэсэн өө сэв гарган асуудал үүсч, тэр үед 13 мянга гаруй хувиар хэвлэгддэг байсан сонины нэгэн дугаар буюу 13 мянган сониныг уурын зуух руу хийж, шатаан устгаж⁷ байж билээ.

Монголчууд галын дөл өөдөө гэдэг. Зах зээлийн ээдрээ нугачаанд хэвлэдэг тоо нь цөөн болсон ч дугаараа тасалж хаалгаа барьсангүй. “Орон нутгийн шилдэг хэвлэл”-ээр 1997, 2000, 2005, 2013 онд дөрвөн удаа шалгарч шагнал хүртжээ.

Эцэст нь тэмдэглэхэд, захиргаа-далтын үеийн нэг намын хяналт цензур төв, орон нутгийн аль ч хэвлэл сонинд нийтлэг байсан ч бүтэн дугаараа шатаалгасан нь Монголын сэтгүүл зүйн анхны тохиолдол юм. Орон нутгийн хэвлэлээс нэрээ солиогүй ганцаараа үлдсэн ч толгойн үсгийн шриффтээ 16 удаа сольжээ.

Ишлэл

1. “Эрх чөлөө” сонин 1946 № 10

2. “Хөвсгөлийн их хөлгөн судар буюу “Эрх чөлөө” сонин” Мөрөн хот. 2014 он, 15 дугаар тал
3. Мөн ном 20-21 дүгээр тал
4. Л.Норовсүрэн, М.Зулькафиль, Ч.Чойсамба “Монголын сэтгүүл зүй-100 жил: Хамгийн хамгийн хамгийн” Уб, 2013, 118 дугаар тал
5. “Хөвсгөлийн их хөлгөн судар буюу “Эрх чөлөө” сонин” Мөрөн хот. 2014 он, 26-27 дугаар тал
6. Мөн ном 43-44 дүгээр тал
7. “Ардчилал” сонин 2019.10.01 № 184

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. “Ардчилал” сонин 2019.10.01 № 184
2. “Хөвсгөлийн их хөлгөн судар буюу “Эрх чөлөө” сонин” Мөрөн хот. 2014
3. “Эрх чөлөө” сонины дугаарууд

Резюме

В данной статье автор описывает специфику региональной печати Монголии на примере газеты “Эрх чөлөө” (“Свобода”) Хубсугульского аймака. Дается краткая характеристика деятельности редакции и исторический обзор газеты, имеющей 70 летнюю историю. Также автор статьи отмечает то, что газета “Эрх чөлөө” несколько раз подвергалась цензуре и в качестве примера автор приводит такой факт, как выпуск газеты выходивший тиражом 13000 был уничтожен. “Эрх чөлөө” является наиболее успешной региональной газетой и была удостоена премии как лучшая региональная пресса.